ТЭД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
11-р хороолол, Их сургуулийн
гудамж 40-р байр 7 тоот
Утас: 99190483, 976-11-350953
И-мэйл: tedaudit96@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МАНИПОСТ ББСБ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Манипост ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв.Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Нягтлан бодох бүртгэлийн хууль, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулахад хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн

тайлангуудыг бэлтгэх, боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

<u>Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага</u>

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухай бүр нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийлэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний

тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

“ТЭД-АУДИТ” ХХК

ЗАХИРАЛ В.ОЮУНЧИМЭГ

2025 оны 01-р сарын 24-нд

"МАНИПОСТ ББСБ" ХХК

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	635,303,315.26	23,194,769.31
Зээл	1,974,240,889.52	2,643,750,889.52
Факторингийн тооцооны авлага		
Үүсмэл санхүүгийн хөрөнгө		
Хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
Бусад санхүүгийн хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
Санхүүгийн хөрөнгийн дүн	**2,612,544,204.78**	**2,669,945,658.83**
Санхүүгийн бус хөрөнгө		
Татвар, НДШ-ийн авлага		
Үндсэн хөрөнгө	2,357,867.69	1,447,769.11
Биет бус хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**2,357,867.69**	**1,447,769.11**
НИЙТ ХӨРӨНГӨ	**2,614,902,072.47**	**2,671,393,427.94**

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Санхүүгийн өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		
Бусад эх үүсвэр		
Үүсмэл санхүүгийн өр төлбөр		
Бусад санхүүгийн өр төлбөр		
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.00	0.00
Санхүүгийн өр төлбөрийн дүн		
Санхүүгийн бус өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өр төлбөр	2,747,015.26	2,699,576.07
Нөөц /Болзошгүй өр төлбөр /		
Хойшлогдсон татварын өр төлбөр		
Бусад санхүүгийн бус өр төлбөр	2,747,015.26	2,699,576.07
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**2,747,015.26**	**2,699,576.07**
Өр төлбөрийн нийт дүн		
Эзэмшигчдийн өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,500,000,000.00	2,500,000,000.00
Өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	112,155,057.21	168,693,851.87
Эзэмшигчдийн өмчийн дүн	**2,612,155,057.21**	**2,668,693,851.87**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	**2,614,902,072.47**	**2,671,393,427.94**

Аудитор: /Н.Дэлгэрмаа/

2025 оны 01 сарын 24 нд

"МАНИПОСТ ББСБ" ХХК

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2023.12.31	2024.12.31
Хүүгийн орлого		
Банканд байршуулсан хөрөнгийн	174,948.05	220,869.55
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		
Зээлийн	154,153,637.00	208,740,803.00
Үнэт цаасны		
Бусад	947,274.00	694,981.00
(Хүүгийн орлогын буцаалт)		
Хүүгийн орлогын дүн	**155,275,859.05**	**209,656,653.55**
Хүүгийн зардал		
Итгэлцлийн үр шим		
Зээлийн		
Үнэт цаасны		
Бусад		
(Хүүгийн зардлын буцаалт)		
Хүүгийн зардлын дүн	**0.00**	**0.00**
Хүүгийн цэвэр орлого	**155,275,859.05**	**209,656,653.55**
Эрсдэлийн сангийн зардал		
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**155,275,859.05**	**209,656,653.55**
Бусад орлого	697,000.00	2,290,000.00
Хүүгийн бус зардал	43,011,004.15	40,870,734.58
Үйл ажиллагааны бус зардал		1,715,254.00
Татварын төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	**112,961,854.90**	**169,360,664.97**
Орлогын татварын зардал	1,209,618.55	1,710,759.19
Татварын дараах ашиг (алдагдал)	**111,752,236.35**	**167,649,905.78**
Бусад дэлгэрэнгүй орлого		
Цэвэр ашиг (алдагдал)	**111,752,236.35**	**167,649,905.78**

Аудитор: /Н.Дэлгэрмаа/

2025 оны 01 сарын 24 нд

"МАНИПОСТ ББСБ" ХХК

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	**2,500,000,000.00**			**388,402,820.86**	**2,888,402,820.86**
Тайлант хугацаанд нэмэгдсэн					-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	**2,500,000,000.00**	**-**	**-**	**388,402,820.86**	**2,888,402,820.86**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				111,752,236.35	**111,752,236.35**
Зарласан ногдол ашиг				(388,000,000.00)	**(388,000,000.00)**
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	**2,500,000,000.00**	**-**	**-**	**112,155,057.21**	**2,612,155,057.21**
Тайлант хугацаанд нэмэгдсэн					-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	**2,500,000,000.00**	**-**	**-**	**112,155,057.21**	**2,612,155,057.21**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				167,649,905.78	**167,649,905.78**
Зарласан ногдол ашиг				(111,111,111.12)	**(111,111,111.12)**
Хувьцаат капиталын өсөлт					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	**2,500,000,000.00**	**-**	**-**	**168,693,851.87**	**2,668,693,851.87**

Аудитор: /Н.Дэлгэрмаа/

2025 оны 01 сарын 24 нд

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2023.12.31	2024.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**3,552,488,041.05**	**2,018,998,653.55**
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	2,248,908,819.00	1,122,925,784.00
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан		
Бусад	1,303,579,222.05	896,072,869.55
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**2,905,800,045.87**	**2,631,107,199.50**
Олгосон зээл	1,898,150,000.00	1,664,600,000.00
Буцаан олгосон итгэлцэл, үр шим		
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн		
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн		
Ажиллагсдад олгосон	20,496,463.83	24,663,700.00
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,414,225.54	14,518,351.90
Ашиглалтын зардалд төлсөн		
Бусад мөнгөн зарлага	946,739,356.50	927,325,147.60
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**646,687,995.18**	**(612,108,545.95)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**0.00**	**0.00**
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		
Мөнгөн зарлагын дүн	**0.00**	**0.00**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**0.00**	**0.00**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан болон бусад орлого		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөр, ногдол ашигт төлсөн мөнгө	350,000,000.00	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(350,000,000.00)**	**0.00**
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**296,687,995.18**	**(612,108,545.95)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**338,615,320.08**	**635,303,315.26**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**635,303,315.26**	**23,194,769.31**

Аудитор: /Н.Дэлгэрмаа/

2025 оны 01 сарын 24 нд

Эдгээр тодруулгууд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр: **"Манипост ББСБ" ХХК**
Регистрийн дугаар: **5020743**
Үйл ажиллагааны чиглэл: **Зээлийн үйл ажиллагаа**

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

Тус байгууллага нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараахь бүртгэлийн бодлогуудыг баримталдаг.

2.1 Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал, тайлант жилд гарсан онцлох өөрчлөлтүүд

Тус байгууллагын 2024 оны Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна. Байгууллага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, тодруулгуудыг бэлтгэсэн байна.

2.2 Санхүүгийн тайлагналын суурь

Байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, аккруэл сууриар бэлтгэгдсэн байна.

2.3 Санхүүгийн тайланг бэлтгэсэн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайланг байгууллагын үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох Монгол улсын төгрөгөөр илэрхийлсэн.

2.4 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

2.5 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн гадаад валют болон суурь валютын хоорондох валютын ханшийг ашиглаж, гадаад валютын дүнг суурь валютад хөрвүүлэн анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэдэг.

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Хөрвүүлэлтээс үүдсэн ханшийн зөрүүг орлогын тайланд бүртгэнэ. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдэд хамааралтай гадаад валютаарх ашиг, алдагдал дэлгэрэнгүй орлогын тайланд бусад орлогын хэлбэрээр толилуулна.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлнэ.

2.6 Нягтлан бодох бүртгэлийн түсгай бодлого

Санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримталдаг байна.

2.6.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь төгрөгийн касс болон банкин дахь төгрөг, валют, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг.

Мөнгөн хөрөнгийн нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг балансын өдрөөрх Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг

2.6.2 Санхүүгийн хэрэгсэлүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад бэлэн мөнгө, богино хугацаат хадгаламж, дансны авлага болон бусад авлага өглөгөөс бүрдэнэ.

Санхүүгийн хөрөнгүүдийг эхлэж бодит үнэ цэнээр нь бүртгэх ба бүх худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь, зээл болон зээллэгийг шууд хамааралтай зээлийн зардлын нийлбэр дүнгээр хүлээн зөвшөөрнө. Байгууллагын санхүүгийн өр төлбөрт дансны өглөг, бусад өглөг, зээл, зээлийн хүүгийн өглөг багтана.

Авлага

Зээл болон авлага нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө үйлчлүүлэгчээс авах авлагын дүн орно.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

НДШ-ийн авлага, ХХОАТатвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татварын авлагын дүн нь татварын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

2.6.3 Бараа материал

Бараа материалын өртөг нь бараа материалыг худалдан авсан өртгөөр тодорхойлогддог. Бараа материалыг дундаж өртөгийн аргаар зарлага болгож, бүртгэлийн байнгын системээр бүртгэнэ.

2.6.4 Орлого

Эдийн засгийн үр ашиг нь байгууллагад орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед хүлээн зөвшөөрнө.

2.6.5 Зардал

Санхүүгийн хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар эдийн засгийн үр өгөөж буурах ба түүнийг бодитой хэмжих боломжтой үед зардлыг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Касс дахь бэлэн мөнгө	250,406,219.11	22,502,590.11
Бэлэн мөнгөний үлдэгдэл	**250,406,219.11**	**22,502,590.11**
Банкин дахь мөнгө	384,897,096.15	692,179.20
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	**384,897,096.15**	**692,179.20**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	**635,303,315.26**	**23,194,769.31**

ТОДРУУЛГА 4. ЗЭЭЛ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Зээл	1,974,240,889.52	2,643,750,889.52
Нийт зээлийн дүн	**1,974,240,889.52**	**2,643,750,889.52**

ТОДРУУЛГА 5. ФАКТОРИНГИЙН ТООЦООНЫ АВЛАГА

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Факторинг тооцооны авлага		
Нийт авлагын дүн	-	-

ТОДРУУЛГА 6. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн үүсмэл санхүүгийн хэрэглүүр		
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр дүн	-	-

ТОДРУУЛГА 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
Нийт дүн	**1,000,000.00**	**1,000,000.00**

ТОДРУУЛГА 8. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
НДШ-ийн авлага		
Нийт дүн	**0.00**	**0.00**

ТОДРУУЛГА 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлтүүд	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
ӨРТӨГ				
Компьютер, бусад хэрэгсэл	5,595,752.00			5,595,752.00
Дүн	**5,595,752.00**	-	-	**5,595,752.00**
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ				
Компьютер, бусад хэрэгсэл	3,237,884.31	910,098.58		4,147,982.89
Хуримтлагдсан элэгдлийн дүн	**3,237,884.31**	**910,098.58**	-	**4,147,982.89**
ЦЭВЭР ДҮН				
Компьютер, бусад хэрэгсэл	2,357,867.69			1,447,769.11
Үндсэн хөрөнгийн нийт дүн	**2,357,867.69**	-	-	**1,447,769.11**

ТОДРУУЛГА 10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Программ хангамж		
Биет бус хөрөнгийн дүн	-	-

ТОДРУУЛГА 11. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Бусад	-	
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	**0.00**	**0.00**

ТОДРУУЛГА 12. САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		
Санхүүгийн өр төлбөрийн дүн	-	-

ТОДРУУЛГА 13 САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
ААНОАТ-ын өглөг	429,443.08	859,944.67
ХХОАТ-ын өглөг	2,317,572.18	1,839,631.40
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**2,747,015.26**	**2,699,576.07**

ТОДРУУЛГА 14. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
А. Өмч:		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,500,000,000.00	2,500,000,000.00
Өмчийн дүн	**2,500,000,000.00**	**2,500,000,000.00**
Б. Хуримтлагдсан ашиг (алдагдал)		
Тайлангийн үеийн ашиг (алдагдал)	111,752,236.35	167,649,905.78
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	402,820.86	1,043,946.09
Хуримтлагдсан ашиг(алдагдал)-ын дүн	**112,155,057.21**	**168,693,851.87**
Эзэмшигчдийн өмчийн дүн	**2,612,155,057.21**	**2,668,693,851.87**

ТОДРУУЛГА 15. ХҮҮГИЙН ОРЛОГО

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Банканд байршуулсан хөрөнгийн	174,948.05	220,869.55
Зээлийн	154,153,637.00	208,740,803.00
Бусад	947,274.00	694,981.00
Хүүгийн орлогын нийт дүн	**155,275,859.05**	**209,656,653.55**

ТОДРУУЛГА 16. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Бусад	-	-
Хүүгийн зардлын нийт дүн	**-**	**-**

ТОДРУУЛГА 17. БУСАД ОРЛОГО

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Зээл хураамж шимтгэлийн орлого	697,000.00	2,290,000.00
Бусад орлогын нийт дүн	**697,000.00**	**2,290,000.00**

ТОДРУУЛГА 18. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Цалин хөлс, шагнал	25,372,173.91	31,420,000.00
Нийгмийн даатгалын зардал	2,852,017.41	2,242,500.00
Зар сурталчилгааны зардал	100,000.00	100,000.00
Элэгдлийн зардал	371,780.59	910,098.58
Шуудан холбооны зардал	480,000.00	480,000.00
Шатахууны зардал	20,000.00	
Бусад зардал	13,815,032.24	5,718,136.00
Үйл ажиллагааны зардлын дүн	**43,011,004.15**	**40,870,734.58**

ТОДРУУЛГА 19. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Бусад зардал		1,715,254.00
Бусад зардлын дүн	**-**	**1,715,254.00**

ТОДРУУЛГА 20. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ/ГАРЗ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн олз		
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн гарз		
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн олз (гарз)-ын дүн	**0.00**	**0.00**

ТОДРУУЛГА 21. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Дансны нэрс	2023.12.31	2024.12.31
Орлогын татварын зардал	1,209,618.55	1,710,759.19
Орлогын татварын зардлын дүн	**1,209,618.55**	**1,710,759.19**

ТОДРУУЛГА 22. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн өдрөөс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

Аудитор: /Н.Дэлгэрмаа/

2025 оны 01 сарын 24 нд

“ТЭД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн
гудамж 40-р байр 3 давхар 7 тоот
УБД: 2097141
Утас: 350953, 99190483
2025.01.23 № СТА/24-02

“МАНИПОСТ ББСБ” ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

УДИРДЛАГАД ТАНИЛЦУУЛАХ ЗАХИДАЛ

Бид танай компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлбар тодруулгуудад гэрээний дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитын тайланг хүргүүлж байна.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

Аудитыг хэрэгжүүлэх явцад бид тус байгууллагын дотоод хяналтын системийг үнэлэхтэй холбоотой горимуудыг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын системийн үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгыг агуулаагүй, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэгдсэн. Бид танай компанийн санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын зохион байгуулалтад ямар нэг материаллаг алдаа илрүүлээгүй болно.

Биднийг аудит хийх үеэр хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн танай ажилтнуудад талархаж байгаагаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ **В.ОЮУНЧИМЭГ**

2025.01.23 нд